

МОНГОЛЫН ХҮН АМЫН СЭТГҮҮЛ

Дугаар (499) 29, 2019



МУИС ПРЕСС ХЭВЛЭЛИЙН ГАЗАР

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Хүн амын сургалт, судалгааны төв, Монголын хүн ам, хөгжил нийгэмлэгтэй хамтран “Монголын хүн амын сэтгүүл”-ийн 29 дэх дугаараа бэлтгэн, эрхэм уншигч Та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн энэ дугаарын “Судалгаа” хэсэгтээ Монгол Улсын гадаад болон дотоод шилжилт хөдөлгөөний талаарх судалгаа, шинжилгээний дэлгэрэнгүй үр дүнг онцлон хүргэж байна. Сүүлийн жилүүдэд Монгол Улсын гадаад, дотоод шилжих хөдөлгөөний эрч хүч буурахгүй, ялангуяа, ажиллах хүчний шилжилт жилээс жилд улам нэмэгдэж байна. Шилжигчдийн талаарх албан ёсны тоо мэдээллийн ач холбогдол, мэдээллийн хүртээмжтэй байдал, мэдээллийг бий болгох зайлшгүй хэрэгцээ шаардлага, хүн амын дотоод шилжилтэд нөлөөлөгч нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн талаарх эконометрикийн шинжилгээ болон дотоод шилжилт хөдөлгөөнд оролцогчдод тохиолдож буй бэрхшээл, сорилт, тэдгээрийг даван туулах стратегийн талаарх судалгааны үр дүнг Та бүхэнд танилцуулж байна.

Мөн эрүүл мэндийн зардлаас үүдэн санхүүгийн сүйрэлд өртсөн өрх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон судалгааны үр дүнтэй танилцана. Тус судалгааны үр дүнгээс харахад, манай улсын 100 өрх тутмын 1 нь суурь хэрэглээнээс бусад зардлынхаа 40 ба түүнээс дээш хувийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээндээ зарцуулж, санхүүгийн сүйрэлд өртсөн байна. Гуравдагч шатлалын болон хувийн эмнэлгээр үйлчлүүлэх үеийн санхүүгийн эрсдлийг бууруулах, тусламж үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлэхэд түлхүү анхаарсан бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт хийх шаардлагатайг энэ судалгааны үр дүн харуулж байна.

“*Үзэл бодол*” хэсэгт боловсролын салбар дахь өөрчлөлт, шинэчлэлт нь “*ори, үйл явцыг чухалчилсан тогтолцоо*”-ноос “*үр дүн, чадамжийг чухалчилсан тогтолцоо*”-нд шилжих чиглэлд буй бөгөөд мэргэшлийн хүрээ (qualifications framework)-г салбар, улс, бүс нутгийн хэмжээнд бүрдүүлж, үр дүнд суурилсан тогтолцооны “*малгай*” хэлбэрээр хэрэглэх нь түгээмэл байгаа болон өөрчлөлт, шинэчлэлтийн энэ давалгаа Монгол Улсыг ч тойрсонгүй, үр дүнд суурилсан тогтолцоог боловсролын чанарыг сайжруулах үндсэн арга болгох, энэ хүрээнд Үндэсний мэргэшлийн хүрээ (National Qualifications Framework)-г бий болгох ажлыг хийх шаардлагатай байна. Аливаа арга хэмжээний үр дүнтэй хэрэгжилт нийтээрээ уг арга хэмжээний талаар нэгдсэн ойлголттой болж чадсан эсэхээс ихээхэн хамаардаг тул үүнд багахан хувь нэмэр оруулах зорилгоор мэргэшлийн хүрээ гэж юу болох, түүний бүтэц бүрэлдэхүүн, Монгол Улсын хувьд ямар загвартай байж болох талаар хэлэлцүүлэг өрнүүлж байна.

“*English*” хэсэгтээ Монголчуудын зонхилох үндэстэн (халх) болон угсаатны цөөнхийн нийгэм-эдийн засгийн байдал, амьжиргааны түвшинг харьцуулсан судалгааны үр дүн болоод Монгол Улсын Хүнсний талон хөтөлбөр хөдөлмөр эрхлэлтийг урамшуулахад үзүүлсэн нөлөөллийн талаарх судалгааны үр дүнг тус тус танилцуулж байна. Эхний судалгаа зонхилох үндэстэнтэй харьцуулсан угсаатны цөөнхүүдээр ангилсан задгай мэдээлэл цуглуулах, хүн амын олонх ба угсаатны цөөнхийн хооронд гарч байгаа амьжиргааны түвшний болон эдийн засгийн үзүүлэлтийн ялгаа, учир шалтгааныг илүү тодруулах, алслагдсан бүс нутгуудад амьдарч буй угсаатны цөөнхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд илүү анхаарах шаардлагатай болохыг зөвлөжээ. Харин хоёр дах судалгаагаар хүнсний талон хөтөлбөрт хамрагдсанаар хүмүүс Засгийн газар болон хандивлагчдийн дэмжлэгээс хараат болох төлөвтэй болж, ядуурлыг бууруулах, амьжиргааг дэмжихэд нөлөөлж чадахгүй байна. Иймд

хүмүүсийн хөдөлмөр эрхлэхгүй байх сөрөг хандлагыг өөрчлөхөд чиглэсэн хөтөлбөрийн хувилбарыг бий болгох хэрэгтэй талаар зөвлөмж гаргажээ.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт толилуулж буй судалгаа, эрдэм шинжилгээний ажил, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар эрхэм уншигч Та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, санал бодлоо хуваалцаж, манай дараагийн дугаарт өөрийн материалаа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Энэ ялдамд хүн ам зүй, хүн ам, хөгжлийн асуудлаар судалгаа, шинжилгээний ажилд оюун санаагаа зориулан манай сэтгүүлд өөрийн бүтээлээ ирүүлсэн нийт эрдэмтэн, судлаачид болон уг сэтгүүлийн энэ дугаарыг бэлтгэн хэвлэхэд санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Монгол улсын их сургуульд сэтгүүлийн редакцийн хамт олон гүн талархлаа илэрхийлж байна.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ТОВЬЁОГ

хуудас

МОНГОЛ ХЭСЭГ: СУДАЛГАА**Монгол улс: Ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөн***Цогтсайханы Болормаа, (Ph.D)* 9**Эрүүл мэндийн зардлаас үүдэлтэй өрхийн санхүүгийн сүйрэлд нөлөөлж буй хүчин зүйлс***Тахадын Өнөрцэцэг, (MA)* 19*Алгаагийн Солонго, (Ph.D)* 19*Дандарчулууны Хишигт, (Ph.D)* 19**Монгол улсын хүн амын дотоод шилжих хөдөлгөөнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох нь***Баатарын Наранчимэг, докторант* 30**Хүн амын дотоод шилжих хөдөлгөөн: Бэрхшээл, сорилтууд***Цогтсайханы Болормаа, (Ph.D)* 50*Чимэдцэрэнгийн Цогтбаяр, магистрант* 50**ҮЗЭЛ БОДОЛ:****Мэргэшлийн хүрээ гэж юу вэ?***Гэлэгийн Цагаач, (Ph.D)* 60**ENGLISH SESSION: RESEARCH****A study of some less-known features of ethnic minority people in Mongolia***Anura Widana, (Ph.D)* 70*Solongo Alгаа, (Ph.D)* 70**The contributing factors for work disincentive resulted from Food Stamp Program: The case of Mongolia***Narantuya Rentsenbyamba, (MA)* 80**СЭТГҮҮЛД ХЭВЛЭГДЭХ МАТЕРИАЛЫН СТАНДАРТ** 91